



МОНГОЛЫН
АРДЧИЛСАН
ХӨДӨЛГӨӨНИЙ
НАМЫН VI БҮГД ХУРЛААС БАТЛАВ.
УАГ-ын 1/97 тоот албан шаардлагын дагуу
Удирдах зөвлөлийн №УЗ-16/01 тоот шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулав.

2016 оны Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн мөрийн хөтөлбөр

Монгол Улсын ардчиллын ууган байгууллага болох МоАХ-ны анхдагч гишүүдийн үүсгэл санаачлага, монгол түмний итгэл дэмжслэгээр байгуулагдсан – Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам нь:

Цагаан морин жилийн Ардчилсан хувьсгалаас хойшихи өнөөдрийг хүртэлх 26 жилийн улс нийгмийн амьдралд дүн шинжлэл хийсний үндсэн дээр “Шинэ бодлого, шинэ хандлага, шударга ёсны үнэлээмж”-ийг удирдлага болгон арчилал, шударга ёс, эв нэгдэл, тусгаар тогтнолоо дээдэлсэн Мөрийн хөтөлбөрөө тунхаглаж байна.

Уг Мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа Монголын Ардчилсан Хөдөлгөөний Намын өөрийнх нь Мөрийн хөтөлбөр, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжууд буюу “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”, “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”, “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хууль” зэрэг хуулиудыг үндэс болгосон болно.

1. МӨНГӨНИЙ ТӨРИЙГ АРД ТҮМНИЙ ТӨР БОЛГОЁ!

1.1. “Оюунлаг төр – ёс зүйтэй парламент – чадварлаг засгийн газар” гэсэн тэнцвэрт харьцааг төрийн боловсон хүчний бодлогоор төлөвшүүлнэ.

1.2. Төрийн чиг үүргийн төвлөрлийг сааруулж, төр болон иргэд, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын түншлэлийг хангасан хариуцлагатай засаглалыг төлөвшүүлнэ.

1.3. Сонгуулийн тогтолцоог шударга болгох, ард түмний сонголтыг хамгаалах эрх зүйн орчныг төгөлдөршүүлнэ.

1.4. Эдийн засгийг ил тод, шударгаар засаглаж, ард түмний ахуй амьдралыг тэтгэх бодлого боловсруулахад анхаарна.

1.5. Улс төрд нэр цэвэр, сэтгэл цэвэр, гар цэвэр байх зарчмыг нэвтрүүлж, ард түмнээ үлгэрлэнэ.

1.6. Шударга бус аливаа илрэлтэй эвлэршгүй тэмцэж, шударга ард түмнийг төлөвшүүлнэ.

1.7. Гадаад орнуудад ажиллаж амьдарч буй монгол иргэд нь Монгол төрийн үндсэн баялаг мөн болохоор үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын нэгээхэн хэсэг хэмээн үзэж, эрх ашгийг нь хуульчлан хамгаална.

1.8. Тогтвортой засаглал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн

гол нөхцөл мөн тул тогтвортой засаглал, тогтвортой хөгжлийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарна.

1.9. Засаглалын хариуцлага, чадамж, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч, тогтвортой хөгжлийг хангахыг зорино.

1.10. Гадаад бодлого бол Монгол Улсын тусгаар тогтнолын нэгэн баталгаа мөн тул онцгой анхаарч, эрх тэгш, харилцан ашигтай, олон тулгуурт хамтын ажиллагааг эрхэмлэнэ.

ХОЁР. ЧЕНЖИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ХАЛЖ, АРД ТҮМНИЙ АМЬЖИРГААГ БАТАЛГААЖУУЛНА

2.1. Хоршооллын эдийн засгийг хөгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулж, дотоодын зах зээлийг ард түмэнд эзэмшүүлнэ.

2.2. Монгол хүн бүрийг ажилтай, орлоготой болгохыг хуульчлан шийднэ.

2.3. Ард түмнээ амлалтаар бус, амьдрах арга ухаанаар тэтгэнэ.

2.4. Монополийн буюу ченжийн эдийн засгийг төрийн зохицуулалтаар халж, шударга өрсөлдөөний чөлөөт зах зээлийг төлөвшүүлэх эрх зүйн орчныг сайжруулна.

2.5. Монгол хүн бүрийг үндэсний баялаг үйлдвэрлэгч болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, ядуурлаас гарах, эдийн засгаа тэтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6. Дэлхийн тэргүүлэх дэвшилтэй технологийг эдийн засгийн салбар бүрт нэвтрүүлэхэд бодлогоор анхаарч, инновацийг бүхийл салбарт дэмжин урамшуулна.

2.7. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлж, бэлчээрийн даацад нийцсэн мал сургийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэхэд чиглэсэн хуулийг санаачлана.

2.8. Малчин, тариаланчдын өрхийн аж ахуй эрхлэхийг хөхиүүлэн дэмжих хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, лизинг, хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг авах эрхийг нээх хуулийн төслийг санаачлана.

2.9. Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдийг аялал жуулчлалын дэд бүтцээр хангахад бодлогоор анхаарна.

2.10. Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг өсгөх асуудлыг төрийн бодлогод тусгуулахад анхаарна.

2.11. Үндэсний аюулгүй байдлын бодлогын хүрээнд гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг төрийн тусгай бодлогоор бүрдүүлнэ.

2.12. Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг сайжруулна.

2.13. Дотоодын эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээсээ бүрэн хангах эрх зүйн орчныг анхаарна.

2.14. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

2.15. Санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгож, санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг нэмэгдүүлэх хуулийг санаачлана.

2.16.Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлж, чанарыг сайжруулах эрх зүйн орчныг төгөлдөршүүлнэ.

2.17.Өрийн дарамтаас ард түмнээ гаргахыг нэгэн зорилгоо болгож, холбогдох хуулийг санаачлана.

2.18.Төрийн мөнгөний бодлогыг эрх зүйн хүрээнд шинэчилж, гадаад өрийг багасгах арга замыг эрэлхийлнэ.

2.19.Улс орон, бүс нутаг, нийгмийн хөгжлийг тодорхойлогч хууль, эрх зүйн баримт бичгүүд, төсөл хөтөлбөрүүдэд иргэдийн санал шүүмжлэлийг авдаг механизмыг бий болгож, үр ашгийг нь сайжруулна.

ГУРАВ. АРДЧИЛЛЫН АЛДААГ ЗАСЧ, ШУДАРГА НИЙГМИЙГ ТӨЛӨВШҮҮЛИНЭ

3.1.Монгол төр, нийгэм, гэр бүлд хүртэл үүсэн бий болсон аливаа талцаал хуваагдлыг таслан зогсоноо.

3.2.Төр, нийгмийн аливаа асуудлыг хуйвалдаанаар бус, ил тод, шударга, ардчилсан зөвшилцлөөр шийдвэрлэдэг хэм хэмжээг тогтооно.

3.3.Үндэсний аюулгүй байдал, Монгол түмний эрх ашгийг бусад аль ч улс орны улс төр, эдийн засгийн ашиг сонирхлоос эгнэгт дээгүүр тавих бодлогыг хуульчлан хэрэгжүүлнэ.

3.4.Улс орны хувь заяатай холбоотой томоохон асуудлуудыг ард түмнээсээ асууж байж шийдвэрлэдэг механизмыг бий болгоно.

3.5.Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн үр ашгийг сайжруулах, өрх гэрийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

3.6.Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд онцгой анхаарч, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

3.7.Эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулах эрх зүйн орчныг сайжруулж, зохих хууль тогтоомжид тусгуулна.

3.8.Авлигаас сэргийлэх соён гэгээрүүлэх үйл хэргийг бүх нийтийн үйл хэрэг болгоно.

3.9.Улс төрийг бизнесээс ангид байлгаж, олигархи сүлжээг эрх зүйн шинэчлэлийн хүрээнд таслан төрөө авлигаас хамгаална.

3.10.Лобби хийх нэрийн дор цэцэглэдэг авлигыг таслаж, Лоббины тухай хуультай болно.

ДӨРӨВ. ЭРҮҮЛ БАЙГАЛЬ – ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАТАЛГАА

4.1.Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх хуулийг санаачлана. Үүнд усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх газрыг тусгай хамгаалалтад авах, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах усан сан байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

4.2.Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

4.3.Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, гамшигийн хэмжээнд хүрээд байгаа утаажилт, тоосжилтыг бууруулахад анхаарсан хуулийг санаачлана.

4.4. Байгаль экологийн тэнцвэрийг алдагдуулж, монгол хүний амьдрах орчныг бохирдуулан, үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй аливаа илрэл, үйл ажиллагаатай тэмцэж, таслан зогсоох, хариуцлага тооцох, нөхөн сэргээх, хор хохирлыг арилгах тухай эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

4.5. Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агро-техникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлж, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах эрх зүйт орчныг бүрдүүлнэ.

4.6. Байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилт тавьж, холбогдох хуулиудыг санаачлана.

4.7. Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох хуулийг санаачлана.

4.8. "Эх оронч тунхаг" гаргаж, байгаль орчноо хайрлан хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг монгол хүн бүрийн үйл хэрэг болгоно.

4.9. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн үр ашгийг сайж-руулах бодлогыг хуульчлан хэрэгжүүлнэ.

ТАВ. ХӨДӨЛМӨРЧ, БОЛОВСРОЛТОЙ МОНГОЛ ХҮН - МОНГОЛ ТӨРИЙН ҮНДСЭН БАЯЛАГ МӨН

5.1. Монгол хүн бүрийг эх орны баялгийг бүтээгч, Монгол орны хөгжлийн түүчээ болгохын тулд амьдралын баталгааг нь бүрэн хангах, шударгаар хөдөлмөрлөх нөхцөлийг төрийн бодлогоор бий болгоно.

5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, үр чадвартай залуу үеийг төлөвшүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарна.

5.3. Мэргэжил эзэмшсэн иргэдийн ажлын байраа өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг бодлогоор хуульчлан дэмжинэ.

5.4. Монгол Улсын нэрээр бүтээгдэхүүнээ экспортлодог үндэсний үйлдвэрүүд, компаниуд, иргэдийг төрийн бодлогоор дэмжих хуулийг санаачлана.

5.5. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээнд чанарын шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор хөхиулэн дэмжинэ.

5.6. Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэхийг зорьж, тусгай хуулийг санаачлана.

5.7. Сургалт - судалгаа - үйлдвэрлэлийн түншлэлд түшиглэсэн, олон улсын стандартад нийцсэн дээд боловсрол эзэмших шаталсан тогтолцоог бүрдүүлэх хуулийг санаачлана

5.8. Монгол хүнийг эх оронч үзлээр хүмүүжүүлэх нэгэн хөшүүрэг болох үндэсний түүх соёлын судалгаа сурталчилгааг бодлогоор дэмжүүлнэ.

5.9. Шинжлэх ухаан, технологийн дэлхийд тэргүүлэгч чиглэлүүдийг эх орондоо нэвтрүүлэн хөгжүүлэхэд анхаарч, дээрхи чиглэлээр нарийн мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, сургах, мэргэшүүлэхийг төрийн бодлогоор дэмжүүлэх хуулийг санаачлана.

ЗУРГАА. ЭРҮҮЛ НИЙСЛЭЛ – ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН

- 6.1.**Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхийг хуульчлана.
- 6.2.**Нийслэлийн суурьшлын төвлөрлийг сааруулах хуулийг санаачлана.
- 6.3.**Хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулах хуулийг санаачилж, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгоно.
- 6.4.**Нийслэл хотын усан хангамжийг сайжруулах хүрээнд цэвэр усны шинэ, найдвартай эх үүсвэрийг хайх, олж тогтоох асуудлыг бодлогоор дэмжинэ
- 6.5.**Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгохыг зорилт болгосон хуулийг санаачлана.

**МӨНХ ХӨХ ТЭНГЭР МОНГОЛ ОРНЫГ ИВЭЭЖ,
МОНГОЛ ТҮМНИЙ ЗАЯА БУЯН ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ!**

МОНГОЛЫН АРДЧИЛСАН ХӨДӨЛГӨӨНИЙ НАМ

2016 он



Г СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД Г

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30

2016.04.24 № 448

таяй -ны № -т

Г Нийцлийн талаарх дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцоо бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Монголын ардчилсан хөдөлгөөний намын "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд намын боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Монголын ардчилсан хөдөлгөөний намаас ирүүлсэн "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

Дүгнэлт

Монголын ардчилсан хөдөлгөөний намын Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Монголын ардчилсан хөдөлгөөний намд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД



\\10\10\10\Bichig_Kherieg\Yawsan_Bichig\2016\0425NAG106.Docx

073831

000026